

АЮУЛТАЙ БҮСЭД ОРШИН СУУЖ БҮЙ ӨРХ, ХҮН АМЫН 20 ... ОНЫ СУДАЛГАА

1.ХАЯГИЙН ХЭСЭГ

Дүүргийн нэр:	КОД
Хорооны дугаар:	

1. Хорооны Засаг дарга нь жил бүрийн 1-р сарын 10-ны дотор дүүргийн ЗДТГ-т цахим хэлбэрээр хүргүүлнэ.
2. Дүүргийн ЗДТГ 1-р сарын 15-ны дотор УБ хотын ЗАА-нд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2.МЭДЭЭНИЙ ХЭСЭГ

Аюултай бүс, төрлөөр	МД	20 .. оны эхэнд		20 .. оны эцэст	
		Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн тоо	Хүн амын тоо
А	Б	1	2	3	4
Цахилгааны шугамын хамгаалалтын зурваст	1				
Дулааны шугамын хамгаалалтын зурваст	2				
Цэвэр усны шугамын хамгаалалтын зурваст	3				
Бохир усны шугамын хамгаалалтын зурваст	4				
Үерийн далан сувгийн хамгаалалтын зурваст	5				
Гуу жалганд	6				
Нуур цөөрөм, намгархаг газарт	7				
Голын сав газар, голдиролд	8				
Зам гарцыг тагласан газарт	9				
Химийн хортой үйлдвэрлэлийн ойролцоо	10				
Бусад	11				
Нийт дүн	12				

Бүртгэсэн: Албан тушаал: _____

Гарын үсэг: _____ \

Тамга\тэмдэг

Хянасан: Албан тушаал: _____

Гарын үсэг: _____ \

Аюултай бүсэд оршин сууж буй өрх, хүн амын судалгааны маягт (ЭАБ-14)-ыг нөхөх заавар

Энэ судалгааг хорооны Засаг дарга тогтоосон хугацаанд, цахим хэлбэрээр дүүргийн Засаг даргын тамгын газарт, дүүргийн Засаг даргын тамгын газар судалгааг хороогоор нэгтгэн, тогтоосон хугацаанд, цахим хэлбэрээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд дамжуулна.

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

Дүүргийн нэрийг бүтнээр бичиж, Багануур дүүрэг- **01**, Багахангай дүүрэг- **04**, Баянгол дүүрэг- **07**, Баянзүрх дүүрэг- **10**, Налайх дүүрэг- **13**, Сонгинохайрхан дүүрэг- **16**, Сүхбаатар дүүрэг- **19**, Хан-Уул дүүрэг- **22**, Чингэлтэй дүүрэг- **25** гэсэн кодыг зохих нүдэнд бөглөнө. Хорооны дугаарыг бичиж, кодыг "Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр"-ийг нөхөх заавар болон "Хүн ам" мэдээллийн санг байгуулах заавраас харж нөхнө. Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодыг Нийслэлийн Статистикийн газар (утас 328787, 327946), дүүргийн Статистикийн хэлтсээс болон ubstat.mn цахим хуудсаас энэ кодыг мэдэх боломжтой.

2. МЭДЭЭЛЛИЙН ХЭСЭГ

Хорооны нутаг дэвсгэрт байгаа инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас гэж инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор тодорхой үйл ажиллагаа явуулахыг хуулиар хориглосон газрыг хэлнэ.

Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг **өрх** гэж үзнэ.

Өрх, хүн амын тоо дүүргийн Статистикийн хэлтсээс зөвшөөрсөн оны эхний болон эцсийн өрх, хүн амын тоо байна.

Аюултай бүсэд байгаа өрхийн тоог гаргахдаа мэргэжлийн байгууллагаас албан ёсны зөвшөөрөл авч газар олголт зохих журмын дагуу хийгдсэн газар эзэмших, өмчлөх эрхийн гэрчилгээтэй бол хамруулахгүй болно.

1-р мөрөнд: Цахилгааны шугамын хамгаалалтын зурваст оршин сууж буй өрх, хүн амын тоог бичнэ. **Цахилгааны шугамын хамгаалалтын зурвас** гэж 1кВт хүртэлх шугамд 1-1.5 м, 1-20 кВт-ийн шугамд 2м, 35 кВт-ийн шугамд 4м, 110 кВт-ийн шугамд 5м, 220 кВт-ийн шугамд бол 6 м-ийн зайг захын утаснаас 2 тийш тооцно. Бүх төрлийн цахилгааны хуваарилах байгууламжийн хувьд 20кв хүртэл бол 10м, 35кв-ийнх бол 15, 110кв-ынх бол 20м, 220кв-ынх бол 25м-ийн зайг байгууламжаас тал бүр тийшээ хамгаалалтын зурваст тооцно.

2-р мөрөнд: Дулааны шугамын хамгаалалтын зурваст оршин сууж буй өрх, хүн амын тоог бичнэ. **Дулааны шугамын хамгаалалтын зурвас** гэж дулааны шугамын голоос 2 тийш 500мм хүртэл голчтой шугамын хувьд 5 м, 500 мм-ээс дээш голчтой шугамын хувьд 7м-ийн зай барьсан байхыг хэлнэ.

3-р мөрөнд: Цэвэр усны шугамын хамгаалалтын зурваст оршин сууж буй өрх, хүн амын тоог бичнэ. **Цэвэр усны шугамын хамгаалалтын зурвас** гэж Хот суурины усан хангамж ариутгах татуургын тухай хуульд зааснаар шугамын голоос хоёр тийш 5 метрийн зайг хэлнэ.

4-р мөрөнд: Бохир усны шугамын хамгаалалтын зурваст оршин сууж буй өрх, хүн амын тоог бичнэ. **Бохир усны шугамын хамгаалалтын зурвас** нь хоёр тийш 6 метр зайг, цэвэр усны эх үүсвэр, худгууд мөн хуулийн 17 дугаар зүйлд заасан хэмжээгээр эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсээрээ ялгаатай байдаг.

5-р мөрөнд: Үерийн далан сувгийн хамгаалалтын зурваст оршин сууж буй өрх, хүн амын тоог бичнэ. **Үерийн далан сувгийн хамгаалалтын зурвас** гэж ирмэгээс 10 метр, борооны болон хөрсний ус зайлуулах шугамын тэнхлэгээс 5 метр зайг хэлнэ.

6-р мөрөнд: Гуу, жалганд оршин сууж буй өрх, хүн амын тоог бичнэ. **Гуу, жалга** гэж гадаргуугийн болон булаг шандын ус орж ирж болзошгүй газар.

7-р мөрөнд: Нуур, цөөрөм, намгархаг газарт оршин сууж буй өрх, хүн амын тоог бичнэ. **Нуур, цөөрөм, намгархаг газар** гэж цаг агаарын хуурайшилтаас шалтгаалан хатсан боловч хур тунадас ихтэй жилд намхархаг байдал нь ихсэж хүн байнга амьдрах нөхцөлгүй болсон хэсэг.

8-р мөрөнд: Голын сав газар, голдиргод оршин сууж буй өрх, хүн амын тоог бичнэ. **Голын сав газар, голдирго** гэж голын голдиргол дотор болон гол үерлэхэд усанд автаж болох голын сав газар юм.

9-р мөрөнд: Зам, гарцыг тагласан газарт оршин сууж буй өрх, хүн амын тоог бичнэ. **Зам, гарц тагласан** газар гэсэнд гэр хорооллын гудамж талбайг хаасан буюу авто замаас салбарлан гарсан туслах зам, талбайг хааж буусан айл өрхийг хэлнэ.

10-р мөрөнд: Химийн хортой үйлдвэрийн ойролцоо оршин сууж буй өрх, хүн амын тоог бичнэ. **Химийн хортой бодисын үйлдвэрлэлийн ойролцоо** гэдэгт аж үйлдвэрийн газруудын химийн хортой нөхцөлд ойр байгаа өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын тоог гаргана.

11-р мөрөнд: Дээрх зааварт тусгагдаагүй боловч хүн амьдрах нөхцөл бололцоогүй газарт зөвшөөрөлгүй буусан айл өрхийн тоог оруулна.

1, 2 - р баганад: Тайлант оны эхэнд аюултай бүсэд оршин сууж буй өрх, хүн амыг бичнэ.

3, 4 - р баганад: Тайлант оны эцэст аюултай бүсэд оршин сууж буй өрх, хүн амыг бичнэ. Энэ тоо нь дараа оны жилийн эхний тоотой тэнцүү байна.